



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/54

Булган сум

Аймгийн химийн олимпиад зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны “Засаг даргын нөөц, хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит аймгийн химийн XXIII олимпиадын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Химийн олимпиадыг зохион байгуулахад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.МҮРЭВ-ОЧИР



6326010201

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 03-ны/ний өдрийн
А/АШ... дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОГДОХ АРДЫН БОЛОВСРОЛЫН
ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН, АХМАД БАГШ Ё. ДАРЬСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ
ХИМИЙН XXIII ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын химийн хэл сэтгэлгээ, аргуудыг хэрэглэн асуудлыг шийдвэрлэх, химийн мэдлэгээ ашиглан асуудалд шүүмжлэлтэй хандаж, шийдвэр гаргахад ухамсартай, хариуцлагатай ханддаг, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмждэг, идэвхтэй оролцох ирээдүйн инженерүүдийг бэлтгэх үндсэн суурийг тавихад оршино.

ХОЁР. ХУГАЦАА, ГАЗАР

2026 оны 03 дугаар сарын 21, 22-нд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ, ТӨРӨЛ

Булган аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид.

Нэрэмжит олимпиад нь сурагч, багш, баг гэсэн 3 хэсэгтэй байх ба дараах төрлүүдээр явагдана. Үүнд:

- 8 дугаар ангийн сурагч
- 9 дугаар ангийн сурагч
- 10 дугаар ангийн сурагч
- 11 дугаар ангийн сурагч
- 12 дугаар ангийн сурагч
- Багш (тухайн сургуулийн үндсэн багш байх)

ДӨРӨВ. ОЛИМПИАДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нэрэмжит олимпиад нь дараах зохион байгуулалт дор явагдана. Үүнд:

1. Сурагчийн төрөл: Онол ба дадлага гүйцэтгэсэн онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ. (Улсын химийн олимпиад зохион байгуулалтын адил)

2. Багшийн төрөл: 6 дугаар ангийн “Хүчиллэг ба суурилаг шинж”, 7 дугаар ангийн “Материалын өөрчлөлт”, 8 дугаар ангийн “Давс гарган авах”, “Халах урвал ба идэвхийн эгнээ” нэгжийн суралцахуйн зорилтын хүрээнд:

- нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулна. (ээлжит хичээлийн төлөвлөлт, ажлын хуудас, үнэлгээ)
- хөтөлбөрийн дагуу хичээл заана.
- хөтөлбөрийн биелэлтэд анализ хийж илтгэл бичиж тайлагнана.

3. Сонирхолтой туршилт: Сургуулийн баг нь сонирхолтой 1 сорил, туршилттай ирэх бөгөөд уг сорил, туршилт нь олимпиадын үеэр тавигдана. Энэ нь багийн нийлбэр оноонд бодогдоно.

4.Багийн дүнг төрлүүдийн байр эзэлсэн нийлбэр оноогоор бага онооны системээр тооцож бодно. (төрөлд оролцоогүй бол хамгийн сүүлийн байранд орсноор бодно)

ЗУРГАА. БҮРТГЭЛ.

Олимпиадын бүртгэл 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хүртэл онлайнаар бүртгэнэ. Сурагчийн хувийн хэрэг болон Боловсролын статистикийн мэдээллийн сангийн мэдээллийн системийг үндэслэн мандат олгоно.

ДОЛОО. ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- 1 сурагч зөвхөн 1 төрөлд оролцоно.
- Сурагч нь тухайн сургуульдаа сурдаг, багш нь тухайн сургуульдаа үндсэн багшаар ажилладаг байна.
- Сонирхолтой сорил, туршилт нь шинэлэг, бүтээлч, онолын хувьд алдаагүй, аюулгүй байдлыг хангасан, сонирхол төрүүлсэн, идэвхжүүлсэн гэх мэт үзүүлэлтээс хамаарч үнэлгээний баг үнэлж багийн үнэлгээнд оролцуулна.
- Тогтоосон хугацаанд бүртгүүлсэн байна.
- Сурагч, багш тус бүр мандатын төлбөр 10,000 (арван мянга) төгрөг.

ТАВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ:

Төрөл бүрээр

1 дүгээр байр 1. Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

2 дугаар байр 1. Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

3 дугаар байр 1. Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

Тусгай байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал

Багийн төрөл

1 дүгээр байр 1. Цом, Өргөмжлөл, мөнгөн шагнал

2 дугаар байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал

3 дугаар байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал

Нэмэлтээр

Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит шагнал -
Өргөмжлөл, мөнгөн шагнал

Боловсролын газрын даргын нэрэмжит шагнал - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Өсвөрийн химич - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Шилдэг туршилт - Өргөмжлөл, мөнгөн шагнал

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ИВЭЭЛ ДОР ЗОХИОГДОХ АРДЫН
БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН, АХМАД БАГШ Ё.ДАРЬСҮРЭНГИЙН
НЭРЭМЖИТ БУЛГАН АЙМГИЙН ХИМИЙН ХХИИ ОЛИМПИАДЫН ТӨСӨВ**

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд
1	2	3	4	5	6
1	Багийн төрөл	Ширхэг	3	500,000 400,000 300,000	1,200,000
2	Медаль		18	20000	360,000
3	Цом		1	100,000	100,000
4	Сурагчдын мөнгөн шагнал	Ширхэг	20	1-р байр 150.000 2-р байр 120.000 3-р байр 100.000 4-р байр 80.000	2,250,000
5	Багшийн мөнгөн шагнал	Ширхэг	4	1-р байр 800,000 2-р байр 600,000 3-р байр 400,000 4-р байр 200,000	2.000.000
6	Өсвөрийн химич	Ширхэг	1	100,000	100,000
	Нэрэмжит шагнал	Ширхэг	2	100,000	200,000
7	Бодлого, туршилт худалдан авах	Ширхэг	5	250,000	1,250,000
8	Баннер	Ширхэг	2	200,000	400,000
9	Өргөмжлөл	Ширхэг	30	5,000	150,000
10	Химийн кабинетын багаж, урвалж бодис	Ширхэг	1	7,000,000	7,000,000
Нийт -15,010,000					

Жич: Химийн кабинетын багаж, урвалж бодисын төсвийг хавсаргав.

- Оролцогчдын хоолны зардлыг мандатын төлбөрөөс гаргана.
- Оролцогчдыг Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд байрлуулна.
- Төрийн Ерөнхий боловсролын сургуулийн тоо: Булган аймаг 20 сургууль
- Оролцогчдын зам зардал, томилолтыг тухайн сургууль нь хариуцна.

--o00o--